



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох,
нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 21/769/ТЗ тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр хавсралт ёсоор, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгох байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР

151010814


Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
26.1 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт.



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Сэрүүнхангай" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1	5
2	"Хангарьд девелопмент сити" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.1, 6.2, 6.3, 6.4, 7.1	5
3	"Нарийн хүрэмт" ХХК	Барилга угсралт, шинэ БА-6.2	5
4	"Бат сүндэрлэх цамхаг" ХХК	Барилга угсралт, шинэ БА-2.1, 7.1	5


Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
261 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРЛӨӨР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Ляпислазурь эрдэнэ" ХХК	Зураг төсөл, нэмэлт ЗТ-5.5	-

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
26.1 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Росторг" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-2.1	5
2	"Металл энд вүүд" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-4.1	5
3	"Дөрвөнталст" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-3.7	5
4	"Говь инфрастраткер партнерс" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-3.1	5
5	"Векэн" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-4.1, 8.1	5
6	"Жишиг проект" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-3.1, 4.2	5